

ХЭНТИЙ АЙМГИЙН ДУЛААНЫ СТАНЦЫН 2-Р ХЭЛХЭЭНИЙ ШУГАМ
СҮЛЖЭЭНИЙ ЗАСВАР, ШИНЭЧЛЭЛ 4-Р ЭЭЛЖИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024 оны 5 сарын 21-ний өдөр

Дугаар: ЗД-2024/010

Хэнтий аймаг

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">Улсын Их Хурлын Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг "Алсын хараа 2050" батлах тухай 2020 оны 52 дугаар тогтоол;Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө;Аймгийн Засаг даргын 2021-2025 оны мөрийн хөтөлбөрМонгол Улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарийн 09-ний өдрийн 99 дугаар тогтоол /Өндөрхаан хотыг 2038 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай/;Эрчим хүчний яамнаас хэрэгжүүлж буй "10 аймгийн төвийн дулааны станц барих" төсөл /Хэнтий/
2.	Барилга байгууламжийн байршил, инженерийн шугам сүлжээний одоогийн байдал	<p>Хэнтий аймаг, Хэрлэн сум:</p> <ul style="list-style-type: none">1-р багт байрлах "Баялаг хурах" ХХК-ий шугам сүлжээ1-р багт байрлах "Оч манлай" ХХК-ий шугам сүлжээ1-р багт байрлах "Хэнтий ус" ХХК-ий 5-р зуухны шугам сүлжээ3-р багт байрлах "Ерөөл төгс" ХХК-ий шугам сүлжээ3-р багт байрлах "Чингис Алтайн гайхамшиг" ХХК-ий шугам сүлжээ4-р багт байрлах "Цагаан цахир уул" ХХК-ий шугам сүлжээ5-р багт байрлах "Суно" ХХК-ий шугам сүлжээ <p>Шугам сүлжээний одоогийн байдал:</p> <p>"Баялаг хурах" ХХК-ий зуух: Дулааны 2Ф150-Ф50 мм, цэвэр усны Ф50 мм-ийн голчтой 3 хос шугам, тоосгон болон төмөрбетон худаг сувагчлалтай;</p> <p>"Оч манлай" ХХК-ий зуух: Дулааны 2Ф200-Ф50 мм, цэвэр усны Ф80-Ф50 мм-ийн голчтой 3 хос шугам, тоосгон болон төмөрбетон худаг сувагчлалтай;</p> <p>"Хэнтий ус" ХХК-ий 5-р зуух: Дулааны 2Ф150-Ф80 мм, цэвэр усны Ф65-Ф32 мм-ийн голчтой 3 хос шугам, тоосгон болон төмөрбетон худаг сувагчлалтай;</p> <p>"Ерөөл төгс" ХХК-ий зуух: Дулааны 2Ф150-Ф100 мм, цэвэр усны Ф50 мм-ийн голчтой 3 хос шугам, тоосгон болон төмөрбетон худаг сувагчлалтай;</p> <p>"Чингис Алтайн гайхамшиг" ХХК-ий зуух: Дулааны 2Ф159-Ф76 мм, цэвэр усны Ф89 мм-ийн голчтой 3 хос шугам, төмөрбетон худаг сувагчлалтай;</p> <p>"Цагаан цахир уул" ХХК-ий зуух: Дулааны 2Ф219-Ф76 мм, хэрэглээний халуун усны Ф100, Ф80 мм өгөх буцах, цэвэр усны Ф125-Ф100 мм -ийн голчтой 3 болон 5 хос шугам, төмөрбетон худаг сувагчлалтай;</p> <p>"Суно" ХХК-ий зуух: Дулааны 2Ф150-Ф40 мм, цэвэр усны Ф100-Ф50 мм-ийн голчтой 3 хос шугам, тоосгон болон төмөрбетон худаг сувагчлалтай.;</p>
3.	Объектын бүрэлдэхүүн, хүчин чадал, ажлын биеийн	<p>Шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн ажил</p> <p>"Баялаг хурах" ХХК-ий зуух: Дулааны 2Ф219 мм, хэрэглээний халуун усны Ф80, Ф76 мм өгөх буцах, цэвэр усны Ф125 мм хүртэл голчтой 5 хос шугам, худаг сувагчлалын хамт шинээр төлөвлөх.</p>

<p>параметр</p>	<ul style="list-style-type: none"> - Гол шугам буюу 4-р цэцэрлэг, "Хэрлэн дом" өрхийн эмнэлэг хүртэл нийт 415.23м шугам сүлжээг бүрэн шинэчлэх, /зураг төслийн шатанд нарийвчлан тооцох/ - БОАЖГазрын барилга нь 2021 шинээр ашиглалтад орсон бөгөөд гадна шугам сүлжээ нь төмөрбетон сувагчлал бүхий тус бүр 114,05м урт 3 хос шугаман дээр нэмж хэрэглээний халуун усны өгөх, буцах шугам төлөвлөх, /зураг төслийн шатанд нарийвчлан судлах, шаардлагатай нөхцөлд бетон сувгийг өргөтгөн шинэчлэх/ "Оч манлай" ХХК-ий зуух: Дулааны 2Ф219 мм, хэрэглээний халуун усны Ф159, Ф125 мм өгөх буцах, цэвэр усны Ф159 мм хүртэл голчтой 5 хос шугам, худаг сувагчлалын хамт шинээр төлөвлөх. - Гол шугам буюу Уламжлалт анагаах ухааны эмнэлэг, Стандарт хэмжилзүйн хэлтэс, ГХБХБГазар, Тагнуулын газар, Тэмүүжин цогцолбор сургууль /бага сургууль/, Шүүх, Архивын тасаг, 26 айлын орон сууц, 16 айлын орон сууц, Ханбүргэд орон сууц хүртэл нийт 800,5м шугам сүлжээг бүрэн шинэчлэх, /зураг төслийн шатанд нарийвчлан тооцох/ "Хэнтий ус" ХХК-ий 5-р зуух: Дулааны 2Ф219 мм, хэрэглээний халуун усны Ф80, Ф76 мм өгөх буцах, цэвэр усны Ф150 мм хүртэл голчтой 5 хос шугам, худаг сувагчлалын хамт шинээр төлөвлөх. - Гол шугам буюу Монгол банк, Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК хүртэл нийт 211,26м шугам сүлжээг бүрэн шинэчлэх, /зураг төслийн шатанд нарийвчлан тооцох/ "Ерөөл төгс" ХХК-ий зуух: Дулааны 2Ф219 мм, хэрэглээний халуун усны Ф159, Ф125 мм өгөх буцах, цэвэр усны Ф159 мм хүртэл голчтой 5 хос шугам, худаг сувагчлалын хамт шинээр төлөвлөх. - Гол шугам буюу 2-р цэцэрлэг, Спорт хороо, Шадавдаржаалин хийд, Саран хотхон, 12 айлын орон сууц, Тэмүүжин цогцолбор сургууль, ХХҮГазар, ХГБХХГазар, Номын сан, Татварын алба, Боловсролын газар, Хан Хэнтий чуулга хүртэл нийт 1137,4м шугам сүлжээг бүрэн шинэчлэх, /зураг төслийн шатанд нарийвчлан тооцох/ - Музейн барилга болон Тэмүүжин цогцолбор сургуулийн дотуур байрны барилга нь 2020, 2023 онд шинээр ашиглалтад орсон бөгөөд гадна шугам сүлжээ нь төмөрбетон сувагчлал бүхий тус бүр 149м урт 3 хос шугаман дээр нэмж хэрэглээний халуун усны өгөх, буцах шугам төлөвлөх, /зураг төслийн шатанд нарийвчлан судлах, шаардлагатай нөхцөлд бетон сувгийг өргөтгөн шинэчлэх/ "Цагаан цахир уул" ХХК-ий зуух: Дулааны 2Ф219 мм, хэрэглээний халуун усны Ф80, Ф76 мм өгөх буцах, цэвэр усны Ф100 мм хүртэл голчтой 5 хос шугам, худаг сувагчлалын хамт шинээр төлөвлөх. - Гол шугам буюу аймгийн ЗДТГазар, Хэрлэн сумын ЗДТГазар, ХХААГазар хүртэл нийт 182.2м шугам сүлжээг бүрэн шинэчлэх, /зураг төслийн шатанд нарийвчлан тооцох/ - 2015 онд ашиглалтад орсон Хэрлэн хорооллын 7 орон сууцны гадна инженерийн шугам сүлжээг зураг төслийн шатанд одоогийн байдлыг судлан шаардлагатай нөхцөлд засвар шинэчлэл төлөвлөх, "Чингис Алтайн гайхамшиг" ХХК-ий зуух: Тус халаалтын зуухны хэрэглэгч болох А-01 буюу Чингис цамхаг орон сууц, 10-р цэцэрлэг, А-62 орон сууц, шинэ Чуулгын барилга нь 2015-2023 онд ашиглалтад орсон бөгөөд гадна шугам сүлжээ нь төмөрбетон сувагчлал бүхий тус бүр 442.2м урт 3 хос шугамтай. Төслийн хүрээнд хэрэглээний халуун усны өгөх, буцах шугам нэмж төлөвлөх, /зураг төслийн шатанд нарийвчлан судлах, шаардлагатай нөхцөлд бетон сувгийг өргөтгөн шинэчлэх/ "Суно" ХХК-ий зуух: Дулааны 2Ф219 мм, хэрэглээний халуун усны Ф159, Ф125 мм өгөх буцах, цэвэр усны Ф150 мм хүртэл голчтой 5 хос шугам, худаг сувагчлалын хамт шинээр төлөвлөх. - Гол шугам буюу Т171, Т172, Т173, Т174, Т175 орон сууцнууд, БАМ-ын 1-5-р байр, Т-03 орон сууц, 5-р цэцэрлэг/хуучин/, 8-р цэцэрлэг,
-----------------	---

		<p>Хан Хэнтий цогцолбор сургууль хүртэл нийт 182.2м шугам сүлжээг бүрэн шинэчлэх, /зураг төслийн шатанд нарийвчлан тооцох/</p> <ul style="list-style-type: none"> - 5-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга нь 2023 онд шинээр ашиглалтад орсон гадна шугам сүлжээ нь төмөрбетон сувагчлал бүхий тус бүр 149м урт 3 хос шугаман дээр нэмж хэрэглээний халуун усны өгөх, буцах шугам төлөвлөх, /зураг төслийн шатанд нарийвчлан судлах, шаардлагатай нөхцөлд бетон сувгийг өргөтгөн шинэчлэх/ <p><u>Дулааны сүлжээний усны даралт:</u></p> <ul style="list-style-type: none"> -Дулаан хангамж: өгөх шугамд 2.5 МПа, буцах шугамд 1.6 МПа; -Ажлын биеийн температур: өгөх шугамд 95°C, буцах шугамд 70°C багагүй; -Цэвэр усны сүлжээний усны даралт: 1.6 МПа; -Тооцоот гадна агаарын температур: -39°C; -Газар хөдлөлт даах чадвар: 6 балл. <ul style="list-style-type: none"> • Дулааны станц ашиглалтад ороход одоо байгаа халаалтын зуухыг дулаан хувиарлах төв болгон тоноглож одоо байгаа шугам сүлжээг ашиглахаар тооцно.
4.	Барилгын үндсэн бүтээц, материал, бусад шаардлага	<p><u>Шугам сүлжээ</u></p> <ul style="list-style-type: none"> - Дулааны шугам тоноглолыг орчин үеийн техник, технологийн шийдлийг тусгасан байхаар тооцож сонгох; - 2-р хэлхээний шугам сүлжээг нэг үл нэвтрэх сувагт төлөвлөх. <p><u>Худаг</u></p> <ul style="list-style-type: none"> • Дулаан, цэвэр усны шугамын таслах болон тохируулах хаалттай, салаа шугамын холболт хийх цэгүүдэд худаг төлөвлөх. Холболт шилжүүлэх угсралтын тойм, материалын түүврийг зурагт тусгах; • Цэвэр усны төв шугамын таслах хаалтууд нь БНБД-ийн 40-02-16-д заасны дагуу PN16 ата даах техник үзүүлэлттэй, DIN 3352 F4 стандарт дүйцэхүйц резинэн тольтой задвижкан хаалт байх; • Дулааны болон цэвэр усны салаа шугамыг бүрэн шинэчлэхээр төлөвлөх бөгөөд бүх таслах хаалтуудыг тухайн салааны хэрэглэгчдийн ачааллыг тооцож нэгтгэн өргөтгөж, шугамын голчтой хаалтны дотоод голч нь тэнцүү байхаар дулааны шугамд ган бөмбөлгөн хаалт, цэвэр усны шугамд задвижкан хаалт шинэчлэхээр зурагт тусгах. Ф150 мм түүнээс дээш диаметртэй таслах хаалтыг механик редуктортой байхаар төлөвлөх ба салааны өгөх хаалтны хэрэглэгч талд даралт тохируулах шайба тавих, фланецтай байхаар зурагт тусгах; <p><u>Дулааны шугам хоолой</u></p> <ul style="list-style-type: none"> - ОХУ-ын Ст-20 маркийн ган буюу түүнтэй дүйцэхүйц байна. Шугам хоолойн ханын зузаан 12 мм-ээс багагүй, шулуун оёдолтой, цувимал хоолой байна. Шугам хоолойн булан /отвод/ нь шугамын голчтой ижил ханын зузаантай үйлдвэрийн цутгамал байх; <p><u>Дагалдах тоноглол, үл хөдлөх түлгүүр, гүлсах түлгүүр</u></p> <ul style="list-style-type: none"> • БНБД-ийн 3.05.03-95, БНБД-ийн 40-02-16 шаардлагуудыг хангахуйц ган хийц байна. <p><u>Арматур</u></p> <ul style="list-style-type: none"> - Шугамын өндөр цэгүүдэд агаар гаргах, нам цэгүүдэд юүлэх арматуруудыг стандартын дагуу төлөвлөх; <p><u>Ус буулгагч</u></p> <ul style="list-style-type: none"> - дренажийн системтэй байхаар төлөвлөнө. <p><u>Компенсатор</u></p> <ul style="list-style-type: none"> - Үндсэн компенсатор нь “П” хэлбэрийн эсвэл сиффон байхаар зурагт төсөлд тусгах; <p><u>Дулаалга</u></p> <ul style="list-style-type: none"> • Пенополиуретан материалаар хийж, зузааныг стандартын дагуу сонгоно. <p><u>Дулаалгын гадуурх хамгаалалтын материал</u></p>

		<p>– Ус чийг үл нэвтрэх, гал болон бусад механик үйлчлэлд тэсвэртэй материал сонгоно.</p> <p><u>Суваг</u></p> <ul style="list-style-type: none"> • Төмөр бетон, үл нэвтрэх суваг байна. Зарим онцлох хэсгүүдэд /автозамтай огтолцох хэсэг/ нэвтрэх сувагтай байна. Шугамын трассын дагуу инженер геологийн дүгнэлт гаргаж, хөрсний ус нэвчихгүй байхаар шугамын түвшнийг сонгох. Хэрэв хөрсний усны түвшинд шугам сүлжээг байрлуулахаар бол шугамын сувгийг хөрсний ус нэвчихгүй байдлаар усны хамгаалалтуудыг зураг төсөлд нэмж тусгах; • Газар доорх болон дээрх бусад инженерийн байгууламжтай огтлолцох, давхцах тохиолдол бүрд харилцан нөлөөллийг бууруулах нэмэлт арга хэмжээг тусгах; <p><u>Бусад</u></p> <ul style="list-style-type: none"> – Сувагчлалын трасс дагууд бусад инженерийн шугам сүлжээтэй давхацсан, суулгалтын түвшин ойртсон цэгүүд дээр ашиглагч байгууллагуудтай зөвшилцөж хамгаалалт бэхэлгээ хийх, түвшин өөрчлөх, трасс шилжүүлэх шийдлүүдийг зураг төсөлд тусгах; – Төлөвлөж байгаа зураг төсөлд техникийн зарчмын өөрчлөлт орохоор бол захиалагч болон ашиглагч байгууллагатай зөвшилцөх.
5.	Зураг төсөл боловсруулах үе шат	<p>Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээний засвар, шинэчлэл 4-р ээлжийн ажлын зураг төслийг 1 үе шаттай боловсруулах. /ажлын зураг төсөл/</p> <ul style="list-style-type: none"> • Дэвсгэр зургийн тодруулга хийх; • Инженер геологийн дүгнэлт гаргуулах; • Дулааны болон хэрэглээний халуун ус, цэвэр усны шугамын иж бүрэн ажлын зураг төсөл боловсруулах; • Хяналтын төсөв хийх; • Шугам сүлжээний ажлын зураг төслийг экспертизээр баталгаажуулах.
6.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p>Монгол Улсын хуулиуд:</p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай Монгол Улсын хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Усны тухай хууль; - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; - Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль; - Монгол улсын агаарын чанарын тухай хууль; - Бусад холбогдох хууль тогтоомжууд. <p>Норм, нормативууд:</p> <ul style="list-style-type: none"> - Техник ашиглалтын дүрэм; - Дулааны шугам сүлжээ БНБД 3.05.03.95; - Ус хангамж гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-16; - Дулаан хуваарилах төв БНБД 41-103-11; - Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНБД 23.01.09; - Барилгын дулаан хамгаалалтын төлөвлөлт БД 23-103-10; - Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт БНБД 41-04-13; - ISO 9001, MNS58:30:2007, MNS5420-1:2011 болон холбогдох бусад стандарт, дүрэм журам; - Барилгын тухай хууль, Барилгын норм ба дүрэм, Гадна дулаан хангамж БНБД 41.02.05, Дулааны шугам сүлжээ БНБД 3.05.03.95, Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНБД 23.01.09, бусад холбогдох дүрэм, журам, стандартууд, төсөв зохиох аргачлалууд;

		- Бусад холбогдох дүрэм журмууд.
7.	Ажлын зураг төслийн бүрдэл	<p>Суурь судалгаа: Байр зүйн зураг М1:1000 Инженер-геологийн судалгааны нэгдсэн дүгнэлт</p> <p>Зураглалын материал:</p> <ul style="list-style-type: none"> • Инженерийн шугам сүлжээний нэгдсэн зураг М1:1000; • Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн норм стандартын дагуу төлөвлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх; • Инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндөржилт, улаан шугам М1:1000; • Хамгаалалтын зурвас ногоон байгууламжийн зурвас, цэцэрлэгжилт, М1:1000; • Дагалдах зураг төслүүд /Цахилгаан хангамж, Барилга бүтээц, Холбоо дохиолол/; • Ажлын зургийг үндэслэн хийгдсэн хяналтын төсөв; <p>Тайлбар бичиг:</p> <ul style="list-style-type: none"> • Инженерийн дэд бүтцийн хангамжийн хувилбарууд, төлөвлөлтийн үндсэн шийдэл, концепци; • Техник эдийн засгийн үндэслэл, аргачлал • Төлөвлөлтөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх үе шат, эрэмбэ дарааллыг тодорхойлж хөрөнгө оруулалт, санхүүжилтийн тооцоог төлөвлөлтийн үе шат бүрээр бодитойгоор гаргах; - Зураг төслийг боловсруулахдаа "Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдгийн стандарт" MNS 6736:2018-ыг баримтлан Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь нөхцлийг бүрдүүлж *.shp өргөтгөлтэй гүйцэтгэлийн зураг хүлээлгэн өгөх. - Батлагдсан зураг төслийг (иж бүрэн ажлын зураг төсөл, төсөв, тайлбар бичиг)-г хэвлэмэл болон файл байдлаар (CD-нд бичиж) 3 хувь бэлтгэж, захиалагчид эх хувь 1, хуулбар 2 хувийг хүлээлгэж өгнө.
8.	Галын аюулгүй байдлын нөхцөл	Галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын аюулаас хамгаалах, нөхцөлийг төлөвлөлтөнд тусгах, "Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНБД 21-01-02, "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНБД 21-02-02, "Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгслэл" БНБД 21-04-ийн шаардлагыг хангасан байна
9.	Зураг төсөл зохиоход тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Техникийн нөхцөл, энэхүү зургийн даалгаврын дагуу зураг төслийг боловсруулж, компенсаторын төрлийг ашиглагч, захиалагч байгууллагатай зөвшилцөж сонголт хийнэ. - Зураг төсөлд эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагаар ажлын зураг төсөл, төсөвт магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулах.
11.	Эдийн засгийн тооцоо, төсөв	Барилга байгууламжийн үнэ тооцох норм, дүрэм, шаардлагын дагуу гүйцэтгэнэ.
12.	Зураг төсөл боловсруулах байгууллага	Эрчим хүчний яамнаас олгодог тусгай зөвшөөрлийн 0.07-4.0 МПа /0.7-40.0 кгх/см ² / даралттай дулааны шугам, хоолой, дулаан дамжуулах төвийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах заалт болон тус заалттай дүйцэхүйц зөвлөх үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч эрх бүхий хуулийн этгээд.
13.	Захиалагч байгууллага	Хэнтий аймгийн ЗДТГазар
14.	Зураг төсөл боловсруулах хугацаа	Гэрээнд заасан хугацаанд
15.	Байгаль орчны	Шаардлагатай тохиолдолд байгаль орчны үнэлгээ хийлгэх

16.	<p>үнэлгээ нөхцөл</p> <p>Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт)</p>	<ul style="list-style-type: none"> - Шугам сүлжээний угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх; - Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөлтэй уялдуулах, аймгийн Ерөнхий архитектортой зувшилцөх; - Ажлын зураг төсөлд авто зам, явган зам, гүүр, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн байгууламжийн сэргээн засварлах, тохижуулах ажлын зардлыг холбогдох дүрэм журам, үнэлгээний дагуу тооцон төсөвт тусгах; - Газар доорх болон дээрх бусад инженерийн байгууламжтай огтлолцох, давхцах тохиолдол бүрд шаардлагатай нэмэлт арга хэмжээ авахад гарах зардлыг ажлын зураг, хяналтын төсөвт тусгах.
-----	--	---

ЗӨВШӨӨРӨЛЦСӨН:


Хэнтий аймгийн ЗДТГазрын
ХОХБТХэлтсийн дарга

Хэнтий аймгийн ГХБХБГазрын дарга

"Хэнтий ус" ТӨХК-ий ерөнхий инженер

БОЛОВСРУУЛСАН:

Хэнтий аймгийн Ерөнхий архитектор



2024 оны 5 сарын 21-ний өдөр